



БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/80

Улаанбаатар хот

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд сургалтын цахим систем нэвтрүүлэх, цахим системд суурилсан хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүжилтийн хуваарилалтыг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.1, 8.3.11 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны "Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг батлах тухай" 372 дугаар тогтоол, 2022 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 131 дүгээр тогтоол, 2024 оны "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/11 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Боловсролын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийн 3.3.6 дахь заалт, 2023 оны "Сургалтын цахим систем нэвтрүүлэх, зардал батлах тухай" А/312 дугаар тушаал, "Цахим системд суурилсан сургалтын нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх тухай" А/462 дугаар тушаал, "Цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх, төлөвлөгөө батлах тухай" А/353 дугаар тушаал, "Англи хэлний сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" А/461 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих олон улсын жишигт нийцсэн математикийн сургалтын цахим систем нэвтрүүлэх 2024 оны 1-6 дугаар сарын лицензийн төлбөрт шаардагдах зардлыг нэгдүгээр, цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх 2023-2024 оны хичээлийн жилийн лицензийн төлбөрт шаардагдах зардлыг Пийрсон байгууллагын Монгол Улс дахь албан ёсны төлөөлөгчийн газар (Ай И Ди Си ХХК)-ын 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 2023/0028 тоот албан бичигт санал болгосон үнээр тооцож хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Математикийн сургалтын цахим систем нэвтрүүлэх болон цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой цахим гэрээ байгуулах, лицензийн төлбөр төлөх, худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус зохион байгуулж, төлбөрийг хуваарийн дагуу байгууллагын цахим хэрэглээний зардлаас хэрэгжүүлэгч байгууллагад гэрээнд заасны дагуу хянан шилжүүлэхийг төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.


3.Математикийн сургалтын цахим систем нэвтрүүлэх болон цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой цахим гэрээ байгуулах, лицензийн төлбөр төлөх, худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулахад хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, үр дүнг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнахыг Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газар (Б.Лхагвабаяр)-т, аймаг, нийслэлийн хэмжээнд хяналт тавьж, удирдлага,

20240921

зохион байгуулалтаар ханган ажиллахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Чинтогтох)-т даалгасугай.

ДАРГА



Т.НЯМ-ОЧИР